# ДАРХАН-УУЛ АЙМАГ, “ГУРАВТ” ХХК-ИЙН “ОВООТЫН АЛТНЫ ШОРООН ОРДЫГ ИЛ АРГААР АШИГЛАХ” ТӨСЛИЙН 2025 ОНД ХЭРЭГЖҮҮЛСЭН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН

/АШИГТ МАЛТМАЛЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ДУГААР: MV-012049/
/АЖ АХУЙ НЭГЖИЙН РЕГИСТРИЙН ДУГААР: 2024594/

ДАРХАН-УУЛ АЙМАГ
ХХК
1923040045 БТ4006

БИЕЛЭЛТИЙГ ТАЙЛАГНАСАН:

“ГУРАВТ” ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ: ______________ / Ш.АРИУНБОЛД /

“ГУРАВТ” ХХК-ИЙН
БАЙГАЛЬ ОРЧНЫ АЖИЛТАН ______________/Ч.НАВЧГЭРЭЛ/

2025 он

**АГУУЛГА**

ЗУРГИЙН ЖАГСААЛТ .... 2

1. Тухайн оны уулын ажлын гүйцэтгэлийн товч танилцуулга .... 3

2. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт .... 5

3. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний биелэлт .... 12

4. Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт .... 16

5. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт .... 19

6. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт .... 19

7. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт .... 20

8. Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт .... 21

9. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлт .... 24

10. Аймаг, нийслэлийн Засаг даргын шаардлагаар биелүүлсэн арга хэмжээ .... 26

10.1. Дархан-Уул аймгийн Шарын гол сумын засаг даргатай байгуулсан нийгмийн хариуцлагын хүрээнд байгуулсан гэрээний дагуу .... 26

11. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт .... 28

12. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө, төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчдад тайлагнах төлөвлөгөөний биелэлт .... 28

13. Дүгнэлт .... 30

14. Хавсралт: .... 31

**ЗУРГИЙН ЖАГСААЛТ**

Зураг 1 Уурхайн зам дээр усалгаа хийж байгаа байдал ... 6
Зураг 2 Асгаралтын иж бүрдэл ... 6
Зураг 3 Шимт хөрсний овоолго ... 7
Зураг 4 Ажилчидад сургалт орж буй байдал ... 7
Зураг 5 Усыг зөв зохистой ашиглах мэдээллийн хуудас ... 11
Зураг 6 Техникийн нөхөн сэргээлт хийж дуусcаны дараах байдал ... 13
Зураг 7 Техникийн нөхөн сэргээлт хийсэн талбайн координат ... 14
Зураг 8 Төлбөр шилжүүлсэн баримт ... 15
Зураг 9 Нөхөн сэргээлт хийсэн байдал ... 18
Зураг 10 Нөхөн сэргээлт хийсэн талбайн координат ... 18
Зураг 11 Гал унтраах хэрэгсэл ... 20
Зураг 12 Хог хаягдал хадгалах сав болон хогны саванд ариутгал хийж буй байдал ... 23
Зураг 13 Хог хаягдлаа ачуулж буй байдал ... 23
Зураг 14 Хог тээврийн өөрөө буулгагч авто машин хүлээлгэн өгч буй байдал ... 27
Зураг 15 Уурхайн БОННҮ-г ИНХ-р хэлэлцүүлж буй байдал ... 28

## 1. Тухайн оны уулын ажлын гүйцэтгэлийн товч танилцуулга

“Гуравт” ХХК-ийн “Овоотын алтны шорооон ордыг ил аргаар ашиглах” төсөл нь Дархан-Уул аймгийн Шарын гол сумын Овоот нэртэй газарт оршидог ба Дархан-Уул аймгийн төвөөс зүүн урагш 55км, Шарын гол сумын төвөөс зүүн тийш 12км-ийн зайд байрладаг. Ашигт малтмал, газрын тосны газрын ашигт малтмалын ашиглалтын MV-012049 тусгай зөвшөөрөл бүхий 2007 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн улсын бүртгэлийн 1911004513 тоот гэрчилгээтэйгээр үйл ажиллагаа явуулж байна. Лицензийн талбайн хэмжээ 38.33га юм.

Төслийн хүчин чадал нь сарын 25.86 мян.$м^3$ элс байна. Уурхайг 3 сарын хуцагаанд олборлохоор тооцсон ба нийт ашиглалтын 3 сарын хугацаанд 5.93 мян.$м^3$ хөрс хуулалтын ажил гүйцэтгэж, 25.86 мян.$м^3$ элс олборлож, шлихээр 6.29кг, химийн цэврээр 5.5кг алт олборлохоор төлөвлөн уурхай нь хоногт 12 цагаар 2 ээлжтэй 6 сараас 8 сарын 20 хүртэл нийт 81 хоног ажиллахаар тооцож байсан ч Дархан-Уул аймгийн Байгаль орчны газраас 2025.06.20ны өдөр “Ашигт малтмал олборлох үйл ажиллагааг түр зогсоох тухай” акт ирүүлсний дагуу уурхайд хөрс хуулалт, олборлолтын ажил хийгдээгүй ба зөвхөн дотооддоо 3.3га талбайд техникийн нөхөн сэргээлтийн ажлыг хийж гүйцэтгэсэн. Нөхөн сэргээлтийн ажлын дэлгрэнгүйг “Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний биелэлт” хэсэгт тусгасан.

ГУРАВТ ХХК-Д

**ДАРХАН-УУЛ АЙМГИЙН**
**БАЙГАЛЬ ОРЧНЫ ГАЗАР**
УЛСЫН БАЙЦААГЧИЙН
АКТ

Монгол банкны байрны II давхар, 14 дүгээр баг,
Дархан сум, Дархан-Уул аймаг, 45059
Утас/Факс: (976) 7037-3456
Цахим шуудан: daboajg@gmail.com

2025.06.20 № 01-20-02/196/06.

Ашигт малтмал олборлох үйл ажиллагааг түр зогсоох тухай

Дархан-Уул аймгийн Шарын гол сумын Засаг даргын 2025 оны 03 дугаар сарын 01-ны өдрийн "Хяналт шалгалт хийх" удирдамжийн дагуу мөн Улсын байцаагчийн 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээний хүрээнд Шарын гол сумын Санжинт багийн нутаг дэвсгэрт алт олборлох MV-12049 дугаарын тусгай зөвшөөрөлтэй Гуравт ХХК-ийн ашигт малтмал олборлох үйл ажиллагаанд уул уурхайн компаний талбайд бичиг баримтын бүрдэл ханган ашиглалтын үйл ажиллагаа, нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний хэрэгжилт, нөхөн сэргээлт хийж байгаа байдалд Төрийн хяналт шалгалтын тухай, Ашигт малтмалын тухай, Байгаль орчны тухай багц хуулийн хэрэгжилтэнд хяналт тавих явцын шалгалтад, Байгаль хамгаалагч М. Батнасан, хамт Гуравт ХХК-ний туслан гүйцэтгэх аж ахуйн нэгжийн төлөөлөлийг байлцуулан 2025 оны 06 дугаар сарын 20-ны өдөр урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийлээ..

ТОДОРХОЙЛОХ нь:

Ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй Гуравт ХХК нь MV-012049 лицензийн дугаартай талбайдаа хөрс хуулалтын үйл ажиллагаа хийж хөрсийг зөөвөрлөж үүсмэл нуурын эрэг дээр усан бүү байрлуулан олборлолтын үйл ажиллагаа

---

АКТ ТОГТООСОН:
БАЙГАЛЬ ОРЧНЫ ХЯНАЛТЫН
УЛСЫН БАЙЦААГЧ: Г.АМАРЖАРГАЛ

АКТТАЙ ТАНИЛЦАЖ ХҮЛЭЭН АВСАН:
ГУРАВТ ХХК-НИЙ ГҮЙЦЭТГЭХ
ЗАХИРАЛ /............................/

Тайлбар: Тус компани нь БОХАТБ-д байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ батлуулан гэж өгсөн байгаа. Мөн ерөнхий үнэлгээний дүгнэлт гарсан тул уг актыг хүлээн зөвшөөрөхөөс татгалзаж байна.
Ш.Эрдэнэболд

## 2. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

| Д/д | Байгалийн бүрдэл хэсэг | Сөрөг нөлөөллийг бууруулахаар төлөвлөсөн ажил | Сөрөг нөлөөллийг бууруулахаар төлөвлөсөн ажлын биелэлт | Зардал, төгрөг | Тайлбар |
|---|---|---|---|---|---|
| 1 | Агаарын чанар | Зам талбай, овоолго тоос босох гадаргууг усалгаа хийж тоосжилт бууруулах арга хэмжээ авах | Хуурайшилт ихтэй өдрүүдэд зам талбайн усалгаа хийж ажилласан | 500,000 | Зам талбайн усалгаа хийж буй байдал /Зураг-1/ |
| 2 | Гүний ус | Spill kit асгаралтын иж бүрдэл байрлуулах | Шатах тослох материал алдагдах үед ашиглах асгаралтын иж бүрдэл авч байршуулсан | 750,000 | Асгаралтын иж бүрдэл авч байршуулсан байдал /Зураг-2/ |
| 3 | Хөрсөн бүрхэвч | Техникийн нөхөн сэргээлт хийх | Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний биелэлт хэсэгт тусгасан (3 дугаар бүлэг) | - | |
| 4 | Ургамлан нөмрөг | Шимт хөрсний овоолгыг стандартын дагуу байгуулах, хамгаалах | Уурхайн үйл ажиллагааны үед гарсан хөрсийг шимт хөрсний овоолгонд стандартын дагуу байгуулан, хадгалж байна. | - | Шимт хөрсний овоолго /Зураг-3/ |
| 5 | Амьтны аймаг | Ажилчидад амьтны тухай хууль, байгаль хамгаалах талаар сургалт хийж байх | Ажилчидад сургалт явуулсан | Урсгал зардал | Ажилчидад сургалт орж буй байдал /Зураг-4/ |
| 6 | | Шувууны суулт 2 ширхэг /үүр/ суурилуулах | | | |
| **НИЙТ** | | | | **1,250,000** | |



*Зураг 1 Уурхайн зам дээр усалгаа хийж байгаа байдал*




*Зураг 2 Асгаралтын иж бүрдэл*



*Зураг 3 Шимт хөрсний овоолго*



*Зураг 4 Ажилчидад сургалт орж буй байдал*

"Ус ашиглуулах дүгрнэлт"-ийг Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Усны газраар 2025 оны 9 дүгээр сарын 19-ний өдөр гаргуулж авсан ба уг дүгнэлтийг үндэслэн Хараа-Ерөө голын сав газараас ус ашиглуулах зөвшөөрөл аван мөн тус газартай "Ус ашиглах" гэрээг 2025 оны 09 дүгээр сарын 23-ны өдөр байгуулсан. Уурхайд үйл ажиллагаа явуулаагүй тул ус ашиглагдаагүй.

ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ УСНЫ ГАЗАР

## УС АШИГЛУУЛАХ ДҮГНЭЛТ

2025 оны 09 -р сарын 19 -ны өдөр

Дугаар Е-2507-000329

Улаанбаатар хот Утас: 265528, 265578

**1. Аж ахуйн нэгж байгууллага, захирлын нэр, утас, факс, улсын бүртгэлийн болон регистрийн дугаар**

Оноосон нэр: Гуравт ХХК
Улсын бүртгэлийн дугаар:
Регистрийн дугаар: 2024594
Захирал: Ариунболд
Холбоо барих дугаар: 95158888
Факс :
И-мэйл хаяг :

**2.Төслийн нэр байршил**

Төслийн нэр: овоотын алтны шороон ордыг ил аргаал ашиглах төсөл
Байршил: Дархан-Уул, Шарын Гол, 3-р баг, Санжинт
Харьяалагдах сав газар: Хараа голын сав газар
Хамаарах салбар: Уул уурхай
Төслийн дэлгэрэнгүй: Дархан-Уул аймгийн Шарын гол суманд үйл ажиллагаа явуулах Овоотын орд

**3. Төсөл хэрэгжүүлэгчийн нэр**

Гуравт

**4. Ажиллах горим, хүчин чадал**

| Үргэлжлэх хугацаа | Ажиллах горим | Жилд ажиллах хоног | Хоногт ажиллах ажилчидын тоо | Хоногт ажиллах цаг |
|---|---|---|---|---|
| 3 | 2 ээлжээр | 81 | 28 | 16 |

**5. Үйлдвэрлэх, боловсруулах бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний хэмжээ**

| Ахлын нэр | Тоо хэмжээ | Хэмжих нэгж | Тайлбар |
|---|---|---|---|
| Ашиг олох зориулалтаар ахуйн үйлдвэрлэл, үйлчилгээнд ашиглах усны хэмжээ | 50.0 | хоногт 1 хүн | Уулын ажлын төлөвлөгөөний маягт 3-т; 2 сар ажиллахаар төлөвлөсөн байна. |
| Ашигт малтмал олборлон баяжуулахад ашиглах усны | 14230.0 | тонн | Уулын ажлын төлөвлөгөө маягт 3-т 14230 м3 элс угааж 3.9 кг алт гарган авахаар төлөвлөсөн бөгөөд БОННУТ |

**ХАРАА-ЕРӨӨ ГОЛЫН**
**САВ ГАЗРЫН ЗАХИРГААНЫ ДАРГЫН**
**ТУШААЛ**

2025 оны 09 сарын 23 өдөр Дугаар А/59 Дархан

Ус ашиглуулах зөвшөөрөл олгох тухай

Монгол Улсын Усны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.4, 28.6 дахь заалт, 29 дүгээр зүйлийн 29.1 дэх заалт, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Усны газрын 2025 оны 09 дүгээр сарын 19-ний өдрийн Е-2507-000329 тоот ус ашиглуулах дүгнэлтийг үндэслэн ТУШААХ нь:

1. Хараа голын сав газарт Дархан-Уул аймгийн Шарын гол сумын нутагт орших ашигт малтмалын MV-012049 тусгай зөвшөөрөлтэй, 1911004513 улсын бүртгэлийн дугаартай, 2024594 тоот регистрийн дугаартай "Гуравт" ХХК-нд 2025 онд Хараа голын сав газрын доорх усны нөөцөөс ашиг олох зориулалтаар үйлдвэрлэл үйлчилгээнд ашиглах 57,370.00 $м^3$/жил, уурхайн ухлагад шүүрэн орж ирэх 32,140.80 $м^3$/жил, зам талбайн тоосжилт дарахад ашиглах 102.00 $м^3$/жил, ногоон байгууламжийн усалгаанд ашиглах 3,690.00$м^3$/жил, нийт 93,302.80 $м^3$/жил ус авч ашиглахыг зөвшөөрсүгэй.

2. Усны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.4, 28.6, 29 дүгээр зүйлийн 29.1-д тус тус заасны дагуу ус ашиглах гэрээ байгуулан, энэ хуулийн 7 дугаар зүйлийн 7.5, 28 дугаар зүйлийн 28.7, 28.18, 29 дүгээр зүйлийн 29.1, 30 дугаар зүйлийн 30.1, 31 дүгээр зүйлийн 31.2 дахь заалт болон ус ашиглахад тавигдах шаардлага, эрх үүргийг мөрдөж ажиллах, Улсын усны мэдээллийн сан бүрдүүлэхтэй холбогдуулж ус ашиглалтын тайланг 2025 оны 12 дугаар сарын 20-ний өдрийн дотор үйлдвэрлэлд ашиглагдаж байгаа технологийн усанд хийлгэсэн шинжилгээний дүгнэлт ус ашигласны төлбөрийн мэдээллийг улирал бүр Хараа-Ерөө голын сав газрын захиргаанд ирүүлэхийг "Гурват" ХХК-ийн захирал (Ш.Ариунболд)-д даалгасугай.

3. Тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Шарын гол сумын засаг дарга, Дархан-Уул аймгийн Байгаль орчны газрын дарга нарт зөвлөсүгэй.

Хавсралт 1 хуудастай.

ДАРГА Ө.АРИУНБААТАР

БАТЛАВ:
ХАРАА-ЕРӨӨ ГОЛЫН САВ ГАЗРЫН
ЗАХИРГААНЫ ДАРГА
..........................................Ө. АРИУНБААТАР

БАТЛАВ:
"ГУРАВТ" ХХК-НИЙ ЗАХИРАЛ
..........................................Ш.АРИУНБОЛД

## УС АШИГЛУУЛАХ ГЭРЭЭ

2025 оны 09 сарын 23-ны өдөр | Дугаар 28 | Дархан-Уул аймаг

### Нэг. Ерөнхий зүйл

Усны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.4, 28.6, 29 зүйлийн 29.1-д заасны дагуу Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Усны газрын 2025 оны 09 дүгээр сарын 19-ний өдрийн Е-2707-000329 тоот ус ашиглуулах дүгнэлт, Хараа-Ерөө голын сав газрын захиргаанаас олгосон 2025 оны 09 сарын 23-ны өдрийн А/59 тоот ус ашиглах зөвшөөрлийг үндэслэн: Усны нөөц ашиглуулагчийг төлөөлж Хараа-Ерөө голын сав газрын захиргааны Газарзүй мэдээллийн систем, усны мэдээллийн дэд сан хариуцсан мэргэжилтэн Л.Насанзул, ус ашиглагчийг төлөөлж Дархан-Уул аймгийн Шарын гол сумын Санжинт 3 дугаар багийн нутагт хэрэгжиж буй Овоотын алтны шороон ордыг ил аргаар ашиглах, ашиглалтын MV-012049 дугаартай тусгай зөвшөөрөлтэй, 1911004513 улсын бүртгэлийн дугаартай, 2024594 тоот регистрийн дугаартай "Гуравт" ХХК-ийн захирал Ш.Ариунболд нар ус ашиглах талаар тохиролцон энэхүү гэрээг 2025 оны 09 сарын 24-ны өдрөөс 2025 оны 12 сарын 30-ний өдөр хүртэл байгуулав.

1.2. Гэрээг Монгол хэлээр 2% үйлдэж талуудад нэг хувь хадгалагдах бөгөөд аль ч хувь нь хуулийн хүчинтэй баримт мөн.

1.3. Энэхүү гэрээнд тусгагдаагүй зүйлийг Монгол Улсын холбогдох хуулиар зохицуулна.

### Хоёр. Гэрээний гол нөхцөл

**2.1.Ус ашиглах зориулалт:** Баяжуулах технологид болон, зам талбайн тоосжилт дарах, тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд усалгааны хэрэгцээнд уурхайн шүүрлийн усыг ашиглана. Уурхайд 28 хүн хоногт 2 ээлжээр 16 цаг 81 хоног ажиллана.

**2.2.Нийт ашиглах усны хэмжээ:**

Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2015 оны А/301 тоот тушаалаар баталсан "Нэгж бүтээгдэхүүн үйлдвэрлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэхэд зарцуулах усны хэрэглээний норм"-ын дагуу үйлдвэрлэлийн хэрэгцээний усны хэмжээг тооцоход:

50 хүн * 0.15 м$^3$ * 60 хон = 450.00 м$^3$ – Ашиг олох зориулалтаар үйлдвэрлэл үйлчилгээнд ашиглах усны хэмжээ.

14230 тонн * 4.0 * 1 удаа =56,920.00 м$^3$ Ашигт малтмал олборлон баяжуулахад ашиглах усны хэмжээ.

536 м$^3$ * 1 удаа * 60 хоног = 32,140.80 м$^3$ – Уурхайн ухлагад шүүрэн орж ирэх усны хэмжээ.

1700 м$^2$ * 0.002 м$^3$ * 30 удаа = 102.00 м$^3$ –Зам талбайн тоосжилт дарахад ашиглах усны хэмжээ.

22500м$^2$ *0.004м$^3$ * 1 удаа = 90.00 м$^3$ – Биологийн нөхөн сэргээлт хийхэд ашиглах усны хэмжээ.

5000 ширхэг * 0.04 м$^3$ * 18 удаа = 3600.00 м$^3$ – Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд тарих модонд ашиглах усны хэмжээ.

**Нийт ашиглах усны хэмжээ:** 450.00 м$^3$ + 56,920.00 м$^3$ + 32,140.80 м$^3$ + 102.00 м$^3$ + 90.00 м$^3$ + 3600.00 м$^3$ $^+$ = **93,302.80 м$^3$**

**2.3.Усны чанар, найрлага:** Үйлдвэрийн технологийн уснаас улирал тутам дээж авч




*Зураг 5 Усыг зөв зохистой ашиглах мэдээллийн хуудас байршуулсан болон байршуулахаар бэлтгэсэн байдал*

## 3. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний биелэлт

| Д/д | Нөхөн сэргээлт хийхээр төлөвлөсөн ажил | Нөхөн сэргээлт хийхээр төлөвлөсөн ажлын биелэлт | Зардал | Тайлбар |
|---|---|---|---|---|
| 1 | Нийт 4000мкуб техникийн нөхөн сэргээлт хийх/гадаад овоолго/ | Нийт 3.3га талбайд техникийн нөхөн сэргээлтийн ажлыг хийж гүйцэтгэсэн | Дотоод зардал | Нөхөн сэргээлтийн дараах зураг болон коодинатыг зураг-6,7 аас харна уу |
| 2 | Нийт 4000мкуб техникийн нөхөн сэргээлт хийх/дотоод овоолго/ | | | |
| 3 | Орон нутгаас санал болгосны дагуу “Ногоон Дархан 2032” аяны хүрээнд Хонгор сумын 2-р баг Зулзаган голын нарсан ойг ойжуулах. Жилд 100ш нарс мод тарих | Орон нутагтай тохиролцсоны дагуу мод тарих зардлыг шилжүүлсэн ба тарилт, арчилгааны ажлыг орон нутгаас хариуцахаар болсон | 10,000,000 | Төлбөр шилжүүлсэн баримтыг зураг-8 с харна уу |
| 4 | 1 га газарт биологийн нөхөн сэргээлт хийх | - | - | |
| **НИЙТ** | | | **10,000,000** | |





*Зураг 6 Техникийн нөхөн сэргээлт хийж дууссаны дараах байдал*




*Зураг 7 Техникийн нөхөн сэргээлт хийсэн талбайн координат*



Огноо/Date: 2025-11-22 12:05:02

Шилжүүлгийн мэдээлэл/Transaction information
Журналын /Journal No: 9323034
Гүйлгээний дугаар /Poid: 0

Системийн огноо/System Date: 2025-11-22

| | | | | |
|---|---|---|---|---|
| Дт | IBAN/Дансны/Картын дугаар<br>IBAN/Account/Card number<br>5753239194 | Нэр/Name<br>НОЁН ШАРАВДОРЖ АРИУНБОЛД | Дүн/Amount<br>10,000,000.00 MNT | Ханш/Rate<br>1.00 |
| Кт | Банкны дугаар/Branch No<br>STBMMNUB<br>IBAN/Дансны/Картын дугаар<br>IBAN/Account/Card Number<br>140801873061 | Банкны нэр/Bank Name<br>ТӨРИЙН БАНК<br>Нэр/Name<br>БАТБАДРАХ ДЭЛГЭР | 10,000,000.00 MNT | 1.00 |

Гүйлгээний утга/Transaction description:
12049 ГУРАВТ ХХК тэрбум мод хөтөлбөр утас 95158888

Харилцагч танд баярлалаа./Thank you to our customers

Овог, нэр/Fullname: Рэнцэнбат овогтой Мөнхтуяа / Munkhtuya Rentsenbat
Албан тушаал/Position: Гүйцэтгэх захирал / Chief executive officer
Баталгаажуулах код/Verification code:
D0PUR72W4W96E7AJ

Уг баримт бичиг нь Монгол Улсын "Цахим гарын үсгийн тухай" хуулийн 8.1 дугаар заалтын дагуу тамгыг орлох чадамжтай тоон гарын үсгээр баталгаажсан болно.

*This document is verified by a digital signature that can replace an official stamp under the 8.1st clause of Mongolian Law on Digital Signatures.*

Та https://verify.khanbank.com/ вебсайт руу хандан дээрх 16 орон бүхий кодыг оруулснаар мэдээллийг шалгах боломжтой. Мөн уг холбоосоор дамжин цахим тоон гарын үсгийн тухай дэлгэрэнгүй мэдээллийг авна уу.

*You can verify this document by going to https://verify.khanbank.com/ and entering the 16-digit verification code provided.`You can also find more information about digital signature on this page.*

**Санамж**: Бага дүнтэй (Таван сая төгрөг хүртэлх дүнтэй) гүйлгээ тухайн данс руу шууд шилжих бөгөөд таван сая төгрөгөөс дээш дүнтэй үед хүлээн авагчийн нэр, данс зөрвөл таны данс руу буцан орно. Амжилттай гүйлгээний баримт таны бүртгэлтэй и-мэйл хаяг руу илгээгдэнэ. Ажлын өдрийн 16:00 цагаас хойш болон амралтын өдөр таарсан их дүнтэй (таван сая төгрөгөөс дээш дүнтэй) гүйлгээ дараагийн ажлын өдөр хийгдэхийг анхаарна уу

*Зураг 8 Төлбөр шилжүүлсэн баримт*

## 4. Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

| Д/д | Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө | Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт | Зардал, төгрөг | Тайлбар |
|---|---|---|---|---|
| 1 | Орон нутгаас чиглэл өгсөн газарт техникийн нөхөн сэргээлт хийх | Дархан-Уул аймгийн БОАЖГ-с хувиарлаж өгсөн талбайн 1.1 га д техникийн нөхөн сэргээлтийн ажлыг хийж гүйцэтгэсэн | 80,000,000 | Нөхөн сэргээлт хийсэн зураг болон талбайн координатыг Зураг-9,10с харна уу |
| **НИЙТ** | | | **80,000,000** | |

Дархан-Уул аймгийн БАОЖГ-с хуваарилж өгсөн талбай:



ДАРХАН-УУЛ АЙМГИЙН
**БАЙГАЛЬ ОРЧНЫ ГАЗАР**

Монгол банкны байрны II давхар, 14 дүгээр баг,
Дархан сум, Дархан-Уул аймаг, 45059
Утас/Факс: (976) 7037-3456
Цахим шуудан: daboajg@gmail.com

2025.09.30 № 286
танай ______________-ны № ______________-т

ШАРЫН ГОЛ СУМЫН ЗАСАГ ДАРГА
М.МӨНХБАЯР ТАНАА

Дархан-Уул аймгийн Шарын гол сумын нутагт байрлах эвдэрсэн газрын мэдээллийн санд бүртгэгдсэн "Хавчуу", "Цагаан хөтөл" гэх эвдэрсэн газруудыг "Гуравт" ХХК, "Бага таян" ХХК-уудаар танаас ирүүлсэн саналын дагуу дүйцүүлэн хамгаалах нөхөн сэргээлт хийлгүүлэхээр шийдвэрлэлээ.

"Гуравт" ХХК, "Бага таян" ХХК-уудын дүйцүүлэн хамгаалах нөхөн сэргээх ажилд хяналт тавин хамтран ажиллана уу.

Хавсралт.... хуудастай

ДАРГА Г.БАТБАЯР

Тоот А5



"БАГА ТАЯН" ХХК, "ГУРАВТ" ХХК-уудын дүйцүүлэн хамгаалах нөхөн сэргээх талбай 7.6 га

| Д/Д | Уртраг | | | Өргөрөг | | |
|---|---|---|---|---|---|---|
| | градус | минут | секунд | градус | минут | Секунд |
| 1 | 106 | 29 | 22.27 | 49 | 15 | 34.038 |
| 2 | 106 | 29 | 28.137 | 49 | 15 | 37.437 |
| 3 | 106 | 29 | 28.297 | 49 | 15 | 36.34 |
| 4 | 106 | 29 | 27.1 | 49 | 15 | 34.366 |
| 5 | 106 | 29 | 27.458 | 49 | 15 | 33.555 |
| 6 | 106 | 29 | 29.181 | 49 | 15 | 32.771 |
| 7 | 106 | 29 | 28.776 | 49 | 15 | 31.541 |
| 8 | 106 | 29 | 28.659 | 49 | 15 | 30.471 |
| 9 | 106 | 29 | 34.192 | 49 | 15 | 24.292 |
| 10 | 106 | 29 | 27.628 | 49 | 15 | 21.88 |
| 11 | 106 | 29 | 26.259 | 49 | 15 | 19.605 |
| 12 | 106 | 29 | 21.836 | 49 | 15 | 19.621 |







*Зураг 9 Нөхөн сэргээлт хийсэн байдал*




*Зураг 10 Нөхөн сэргээлт хийсэн талбайн координат*

## 5. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

| Нүүлгэн шилжүүлэх арга хэмжээны төлөвлөгөө | Нүүлгэн шилжүүлэх арга хэмжээны төлөвлөгөөний биелэлт | Зардал, төг | Тайлбар |
|---|---|---|---|
| Төслийн ашиглалтын нөлөөллийн бүсэд малчдын хаваржаа болон зуслан, намаржаа байхгүй | | | |
| **НИЙТ** | | - | - |

## 6. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

| Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө | Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт | Зардал, төг | Тайлбар |
|---|---|---|---|
| Төслийн хэрэгжилтийн явцад ямарваа нэгэн түүх соёлын дурсгалт зүйл олдоогүй ба олдох үед холбогдох хууль тогтоомжинд заасны дагуу засаг захиргааны байгууллага болон холбогдох байгууллага болон ШУА-ийн Түүхийн хүрээлэнд даруй мэдэгдэж төслийн үйл ажиллагааг түр зогсоох болно. | | | |
| **НИЙТ** | | - | - |

# 7. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт

| Д/д | Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл | Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ | Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээний биелэлт | Зардал, төг | Тайлбар |
|---|---|---|---|---|---|
| 1 | Ажилчид болон үйлчлүүлэгчийн бие өвдөх, халдварт өвчин гарах | Ажилчдын эрүүл мэндийн үзлэг | “Альфа оргил” ХХК-иас гэрээт ажилчид авч ажиллуулсан ба тус байгууллагатай хийсэн гэрээний хүрээнд ажилчдын эрүүл мэндийн үзлэгийг гэрээт байгууллага хариуцан ажилласан | Урсгал зардал | |
| 2 | Гал түймэр гарах | Гал унтраах хэрэгслээр уурхайн кемпийг бүрэн хангах арга хэмжээ авах, гал унтраах талаар тодорхой түвшинд бэлтгэлийг хангуулах арга хэмжээ зохион байгуулах | Гал унтраах иж бүрэн хэрэгсэл авч байршуулсан | 740,000 | Гал унтраах хэрэгсэл /Зураг- 11/ |
| **НИЙТ** | | | | **740,000** | |



*Зураг 11 Гал унтраах хэрэгсэл*

## 8. Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт

| Д/д | Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлэх ажлууд | Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт | Зардал, төг | Тайлбар |
|---|---|---|---|---|
| 1 | Хог хаягдал хадгалах зориулалтын цэгт хогийн савыг 3аас доошгүй төрлөөр ялгаж хаях, сумын ТҮК-тэй гэрээ байгуулж нийлүүлэх | Дархан-Уул аймгийн, Шарын гол сумын Засаг даргын тамгын газрын Хот тохижилт хэсгийн даргатай “Хог тээвэх үйлчилгээний гэрээ” 2025.07.25ны өдөр байгуулан, хог хаягдалаа өгч ажилласан | 150,000 | Хог хаягдал түр хадгалах сав /зураг-12/, Хог хаягдал ачуулж буй байдал /зураг-13/ |
| 2 | Аюултай хог хаягдал, аккумулятор, ашигласан тос маслыг цуглуулах түр хадгалах хаягдлын цэг бий болгох<br>Аюултай хог хаягдал устгуулах тусгай зөвшөөрөл бүхий мэргэжлийн байгууллагад нийлүүлэх гэрээ байгуулах | Аюултай хог хаягдал түр хадгалах сав байршлуулсан | 100,000 | Зураг-12 |
| **НИЙТ** | | | **250,000** | |

Дархан-Уул аймаг, Шарын гол сумын ЗДТГ-н Хот тохижилт хэсгийн даргатай байгуулсан хог хаягдлын гэрээ:



БАТЛАВ

ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ Э. ДАМДИНДОРЖ

2025 оны 07 сарын 25

9022597 ТАА0003

**Хог тээвэр үйлчилгээний гэрээ**

2025.07.25 Шарын гол сум

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.16, 22 дугаар зүйлийн 22.1.15 дахь заалт, Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр 9.4 дэх заалт , 10 дугаар зүйлийн 10.2, Зөрчлийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2, 10 дугаар зүйлийн 10.3, 10.4 дэх заалтын дагуу хог хаягдлаас хүний эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, түүнээс урьдчилан сэргийлэх, хог хаягдлыг цэвэрлэх үйл ажиллагаанд иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг татан оролцуулах зорилгоор / цаашид гэрээ гэх/ нэг талаас 2024594 регистирийн дугаартай " Гуравт ХХК " -ийн захирал Ш.Ариунболд , нөгөө талаас ЗДТГ-ыг төлөөлж Хот тохижилт хэсгийн даргын ажилтай Б.Саран нар харилцан тохиролцож энэхүү гэрээг дараах нөхцөлөөр байгуулав.

**Нэг. Ерөнхий зүйл**

1.1 Хог хаягдлын тухай хуулийн хэрэгжилтийг хангах, хуульд заасан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын эрх, үүргийн хэрэгжилтэд хяналт тавьж, сумын хөгжил дэвшил, өнгө үзэмжийг сайжруулахад дэмжлэг үзүүлж хамтран ажиллахад гэрээний зорилго оршино.

1.2 Энэхүү гэрээ нь 2025 оны 07 сарын 25 ны өдрөөс эхлэн **1** жилийн хугацаанд мөрдөгдөнө.

1.3 Гэрээний хугацааг албан ёсоор хүсэлт гарган цуцлаагүй тохиолдолд цаашид жил бүр сунгагдсанд тооцно.

**Хоёр. Оролцогч талуудын үүрэг**

**2.1.Шарын гол сумын ЗДТГ-ын хүлээх үүрэг**:

2.1.1.Сар бүр хог хаягдал тээвэрлэх бөгөөд сумын ИТХ-ын 2019 оны 01 дүгээр сарын 21-ний өдрийн 39 дүгээр тогтоолоор батлагдсан үнэ тарифаар хураамжийг төлүүлэх.

2.1.2. Холбогдох хууль тогтоомжийн дагуу хяналт тавьж, холбогдох мэдээллээр хангаж аиууллах

2.1.3.Гэрээний үүргээ тогтмол биелүүлсэн тохиолдолд сум орон нутгийн зүгээс аж ахуй ажиллагаанд нь дэмжлэг үзүүлэх.

**2.2.Аж ахуй нэгж хүлээх үүрэг:**

2.2.1.Гэрээний үүргээ биелүүлж ажиллах

2.2.2.Хог хаягдал үйлчилгээний хураамжийг сар бүр дансаар тогтоосон хугацаанд



3

**Дөрөв. Бусад нөхцөл**

4.1 Энэ гэрээнд оруулах нэмэлт өөрчлөлт нь бичгээр үйлдэгдэж талууд гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно.

4.2 Аль тал нь энэхүү гэрээгээр хүлээсэн эрх үүргээ нөгөө талын бичгээр өгсөн зөвшөөрөлгүйгээр гуравдагч итгээдэд шилжүүлэхгүй.

4.3 Хүлээсэн үүргээ биелүүлээгүй тохиолдолд зөрчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дүгээр зүйлийн холбогдох заалт болон бусад холбогдох хууль тогтоомжийн дагуу арга хэмжээ авч хариуцлага хүлээлгэнэ.

ТАЛУУДЫН ХАЯГ:

| Гүйцэтгүүлэгч: | Гүйцэтгэгч: |
| --- | --- |
| "Гуравт ХХК "ны захирал | Засаг даргын тамгын газрын |
| Ш.Ариунболд ( ) | Хот тохижилт хэсгийн ахлагч |
| Утас : 95158888 | Б.Саран ( ) |
| | Утас 99406320 |
| Шарын гол сум | Шарын гол сум |
| Санжинт баг | Дархан баг |

ДАРХАН-УУЛ АЙМАГ ГУРАВТ ХХК 1923040045 БТ4006




*Зураг 12 Хог хаягдал хадгалах сав болон хогны саванд ариутгал хийж буй байдал*



*Зураг 13 Хог хаягдлаа ачуулж буй байдал*

## 9. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлт

| Д/д | Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр | Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлт | Зардал, төгрөг | Тайлбар |
| --- | --- | --- | --- | --- |
| 1 | • Төслийн талбайн авто зогсоол,<br>• Ухашны салхин доод талаас жилд 1 удаа<br>– Тоосны агууламж (TSP, PM10, PM2.5)<br>– Нүүрстөрөгчийн дутуу исэл (CO)<br>– Азотын исэл (NOx)<br>– Хүхэрлэг хий ($SO_2$)<br>үзүүлэлтүүдээр агаарын шинжилгээг мэргэжлийн байгууллагаар хийлгэх | Уурхайн эзэмшил талбай болон гадна талбайгаас агаарын хүхэрлэг хий, азотын давхар исэл, нийт тоос болон дуу шуугианы хэмжилт хийлгэсэн. | Дотоод зардал | БОННҮ тайланг боловсруулах явцад гүйцэтгэгч байгууллага сорьц авч шинжилгээ хийлгэсэн ба стандартаар зөвшөөрөгдөх хэмжээнд гарсан |
| 2 | • Төслийн талбайн хог хаягдлын цэг болон ариун цэврийн байгууламжийн цэгт хөрсний хүнд металл болон эрүүл ахуйн бактерийн холимог дээж авах, Шимт хөрсний талбайд хөрсний агрохимийн дээж аван жилд 1 удаа<br>– Хөрсний төлөв байдал бохирдол: хөрсний морфлоги бичиглэл, pH, цахилгаан дамжуулалт, давс %, ялзмагийн агууламж %, шим тэжээлийн элемент ($NO_3$, $P_2O_5$, $K_2O$), хөрсний механик бүрэлдэхүүн, нүүрс устөрөгчийн нэгдлүүд, кадьми, хром, кобальт, зэс, хар тугалга, мангани, никель, цайр зэрэг<br>үзүүлэлтүүдээр хөрсний шинжилгээг мэргэжлийн байгууллагаар хийлгэх | 3 цэгээс сорьц авч<br>– Хөрсний төлөв байдал бохирдол: хөрсний морфлоги бичиглэл, pH, цахилгаан дамжуулалт, давс %, ялзмагийн агууламж %, шим тэжээлийн элемент ($NO_3$, $P_2O_5$, $K_2O$), хөрсний механик бүрэлдэхүүн, нүүрс устөрөгчийн нэгдлүүд, кадьми, хром, зэс, хар тугалга, никель, цайр мөн эрүүл ахуйн шинжилгээ зэрэг<br>үзүүлэлтүүдээр хөрсний шинжилгээг мэргэжлийн байгууллагаар хийлгэсэн | Дотоод зардал | БОННҮ тайланг боловсруулах явцад гүйцэтгэгч байгууллага сорьц авч шинжилгээ хийлгэсэн ба стандартаар зөвшөөрөгдөх хэмжээнд гарсан |
| 3 | • Унд ахуйн усыг хангаж буй гүний худгаас жилд 1 удаа<br>– Усны чанар: pH, ууссан нийт давс (жингийн аргаар), нийт хатуулаг ($CaCO_3$), микробиологи<br>– Бактереологийн шинжилгээ<br>үзүүлэлтүүдээр усны шинжилгээг мэргэжлийн байгууллагаар хийлгэх | • Унд ахуйн ус хангаж буй<br>– Эх үүсвэрийн гүний худаг<br>– Усан сангийн ус<br>– Шугамын ус түгээх №2 байрны ус<br>цэгүүдээс сорьц авч усны химийн болон микробиологийн шинжилгээг "Дархан-Уул аймгийн Стандарт хэмжилзүйн хэлтсийн итгэмжлэгдсэн сорилтын лаборатори"-д хийлгэсэн<br>• Тунгаах сангийн уснаас сорьц авахуулж химийн болон хүнд металлын шинжилгээг Усны хяналтын төв лабораторид хийлгэсэн | Дотоод зардал | "Дулаан шарын гол" ТӨХК-тай 2025.07.21ний өдөр "Цэвэр усаар хангах гэрээ" байгуулан ажилласан. Шинжилгээний дүнгээс харахад стандартаас давсан үзүүлэлтгүй байна. |
| **НИЙТ** | | | **-** | |

“Дулаан шарын гол” ТӨХК-тай 2025.07.21ний өдөр байгуулсан “Цэвэр усаар хангах гэрээ”

БАТЛАВ
“ДУЛААН ШАРЫН ГОЛ” ТӨХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
.............П.БАЯРЦЭЦЭГ

БАТЛАВ
“ГУРАВТ” ХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ
ЗАХИРАЛ ............Ш.АРИУНБОЛД

## ЦЭВЭР УСААР ХАНГАХ ГЭРЭЭ

2025 оны 07 дугаар сарын 21-ний өдөр Дугаар 2025/35 Шарын гол

### НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1.Энэхүү Гэрээг Усны тухай, Хот суурины усан хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийг үндэслэн нэг талаас “Дулаан Шарын гол” ТӨХК, түүнийг төлөөлж Санхүү борлуулалтын хэлтсийн борлуулалтын мэргэжилтэн Э.МӨНГӨНЧИМЭГ (цаашид “Хангагч” гэх), нөгөө талаас 2024594 регистрийн дугаартай “ГУРАВТ” ХХК, түүнийг төлөөлж гүйцэтгэх захирал Ш.АРИУНБОЛД (цаашид “Хэрэглэгч” хамтад нь “талууд” гэх) нар 2025 оны 07 дугаар сарын 21-ний өдрөөс 2025 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэлх хугацаанд цэвэр усаар хангахаар харилцан тохиролцож энэхүү гэрээг байгуулав.

1.2. Энэхүү гэрээгээр хэрэглэгчийн хэрэгцээнд шаардлагатай цэвэр ус нийлүүлэх, цэвэр усны төлбөрийг төлөхтэй холбогдон үүсэх талуудын хоорондын харилцааг зохицуулахад оршино.

### ХОЁР. ТАЛУУДЫН ЭРХ ҮҮРЭГ

**2.1. Хэрэглэгчийн эрх, үүрэг**

2.1.1. Стандартын шаардлага хангасан цэвэр усаар хангахыг хангагчаас шаардах эрхтэй.

2.1.2. Хэрэглэгч дулаан дамжуулах төвийн дэргэдэх цэвэр ус түгээх цэгээс усаа авах ба хангагчийн эрх бүхий ажилтныг байлцуулан авч акт үйлдэнэ.

2.1.3. Цэвэр усны төлбөрийг төлж, эрх бүхий албан тушаалтанаас зөвшөөрөл авсаны дараа усаа авч байх үүрэгтэй.

2.1.4. Цэвэр ус авахдаа хангагчийн шугам сүлжээ, тоног төхөөрөмжийг гэмтэхээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг авах үүрэгтэй.

2.1.5. Цэвэр ус зөөвөрлөх, хадгалах асуудлыг хэрэглэгч өөрөө хариуцна.

**2.2. Хангагчийн эрх, үүрэг**

2.2.1. Хэрэглэгчийн хэрэгцээнд шаардлагатай зохих стандартад нийцсэн цэвэр усаар хангах үүрэгтэй.

2.2.2. Цэвэр усаар хангасны төлбөрийг хугацаандаа төлөхийг хэрэглэгчээс шаардах эрхтэй.

2.2.3. Цэвэр ус зөөвөрлөх автомашин нь аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагыг хангасан байхыг хэрэглэгчээс шаардах эрхтэй. Ус зөөвөрлөх автомашины ёмкост болон ус хадгалах саванд ариутгал, халдваргүйжилт хийгдсэн байхыг хэрэглэгчээс шаардана.

2.2.4. Ус зөөвөрлөх автомашины ёмкос, ус хадгалах саванд ариутгал, халдваргүйжилтийг зохих стандартын дагуу бүрэн хийгээгүйгээс усны чанар, эрүүл ахуй, найрлагад өөрчлөлт орсноос үүдэн бий болсон аливаа хохирлыг хангагч тал хариуцахгүй.

2.2.5. Хэрэглэгч цэвэр ус зөөвөрлөх автомашиныхаа ёмкость, ус хадгалах саваа өөрөө хариуцан ариутгана. Хэрэв ус зөөвөрлөх автомашины ёмкость, ус хадгалах саваа хангагчаар ариутгуулахаар бол албан бичгээр хандаж, гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулж болно.

2.2.6. Хэрэглэгчид цэвэр усаар хангах үйл ажиллагаатай холбоотой мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгч болно.

### ГУРАВ. ТӨЛБӨР ТООЦОО

3.1. Цэвэр усны төлбөрийг Хот суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөлийн тогтоосон тарифаар тооцно.1/нэг/ литр усыг 4.90 /дөрвөн төгрөг ерэн мөнгө / төгрөгөөр тооцож бодно.

3.2. Цэвэр ус зөөвөрлөх автомашины багтаамжаар хэрэглэгчийн авсан цэвэр усны хэмжээг тооцно.

3.3. Хэрэглэгч цэвэр усны хэрэглээний жилийн захиалгыг хавсралтын дагуу сар бүрээр гаргаж, захиалгын дагуу төлбөрийг урьдчилж гэрээ байгуулсан өдөр 400.000 / Дөрвөн зуун мянган/ төгрөгийг хангагчийн касст бэлнээр болон ХААН банкны 5047090007 тоот дансаар төлнө. Төлбөр төлсөн баримтыг үндэслэн хангагчийн ажилтны хяналтан дор цэвэр ус олгоно.

3.4. Хэрэв төлбөрийг төлөөгүй тохиолдолд цэвэр усаар хангахгүй.

### ДӨРӨВ. ХҮЛЭЭХ ХАРИУЦЛАГА

4.1. Хэрэглэгч нь цэвэр усны шугам сүлжээнээс хангагчийн зохих зөвшөөрөлгүйгээр цэвэр ус авсан, шугам сүлжээ, тоног төхөөрөмжийг гэмтээсэн тохиолдолд хангагчид учирсан хохирлыг бүрэн барагдуулна.

4.2. Талуудын аль нэг тал үүргээ зохих ёсоор биелүүлээгүй тохиолдолд нөгөө тал үүргээ биелүүлэх тодорхой хугацаа зааж шаардлага тавих бөгөөд заасан хугацаанд үүргээ биелүүлээгүй нөхцөлд гэрээг цуцлах хүртэл арга хэмжээ авч болно.

### ТАВ. МАРГААНЫГ ШИЙДВЭРЛЭХ

5.1. Энэхүү гэрээтэй холбоотой маргааныг талууд харилцан тохиролцох замаар шийдвэрлэхийг эрхэмлэх ба тохиролцоонд хүрч чадаагүй тохиолдолд зохих хууль, тогтоомжийн дагуу маргаантай асуудлыг Монгол Улсын Шүүхэд хандаж шийдвэрлүүлнэ.

### ЗУРГАА. БУСАД ЗҮЙЛ

6.1.Энэхүү гэрээ нь талууд гарын үсэг зурж баталгаажуулсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.

6.2.Талууд харилцан тохиролцож энэхүү гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулж болох ба нэмэлт өөрчлөлт нь бичгээр үйлдэгдэн талууд гарын үсэг зурж, тамга даран уг гэрээнд нэмэлтээр хавсаргагдана.

### ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

Талууд энэхүү гэрээнд заасан бүхий л нөхцөл заалтуудыг хүлээн зөвшөөрч байгаагаа нотлон доор гарын үсэг зурж баталгаажуулав.

**Хангагчийг төлөөлж:**
“ДУЛААН ШАРЫН ГОЛ” ТӨХК-ийн
СБХ-ийн Борлуулалтын мэргэжилтэн
Э.Мөнгөнчимэг
Утас:99147071

**Хэрэглэгчийг төлөөлж:**
“ГУРАВТ” ХХК-ийн гүйцэтгэх захирал
Ш.АРИУНБОЛД
Утас:95158888

## 10. Аймаг, нийслэлийн Засаг даргын шаардлагаар биелүүлсэн арга хэмжээ

### 10.1. Дархан-Уул аймгийн Шарын гол сумын засаг даргатай байгуулсан нийгмийн хариуцлагын хүрээнд байгуулсан гэрээний дагуу

Ашигт малтмалын тухай хууль, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн дагуу Дархан-Уул аймгийн Шарын гол сумын засаг даргатай “Нийгмийн хариуцлагын талаар хамтран ажиллагах” гэрээг байгуулан. Тус гэрээний хүрээнд “Хог хаягдал тээвэрлэх өөрөө буулгагчтай, задгай тэвштэй автомашин”-г 40,000,000 /дөчин сая/ төгрөгийн өртөгөөр худалдан авч 2025.08.21-ний өдөр орон нутагт хүлээлгэн өгсөн. /Зураг-14/






*Зураг 14 Хог тээврийн өөрөө буулгагч авто машин хүлээлгэн өгч буй байдал*

## 11. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт

| Д/д | Төлөвлөсөн арга хэмжээ | Төлөвлөгөөний биелэлт | Зардал, төгрөг | Тайлбар |
|---|---|---|---|---|
| 1 | Байгаль орчны менежментийн төлөвлөгөө болон биелэлтийн тайланг хугацаандаа танилцуулах, батлуулах | Хугацаандаа хүргүүлэн ажилласан | Дотоод зардал | |
| **НИЙТ** | | | - | |

## 12. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө, төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчдад тайлагнах төлөвлөгөөний биелэлт

| Д/д | БОМТ-ний биелэлтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчидад тайлагнах төлөвлөгөө | БОМТ-ний биелэлтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчидад тайлагнах төлөвлөгөөний биелэлт | Зардал, төгрөг | Тайлбар |
|---|---|---|---|---|
| 1 | 2025 оны БОМТөлөвлөгөөг танилцуулах , батлуулах /цаасан/ | 2025 оны БОМТ-г ХБОБХГ-аар батлуулсан | Дотоод зардал | |
| 2 | БОМТ-ний дагуу хийгдсэн ажлыг тайлагнах /цаасан, зургаар/ | Дархан-Уул аймгийн БОГ-т хүргүүлэн ажилласан | Дотоод зардал | |



*Зураг 15 Уурхайн БОННҮ-г ИНХ-р хэлэлцүүлж буй байдал*

Уурхайн БОННҮ-г Дархан-Уул аймгийн Шарын гол сумын Санжит багийн ИНХ-р хэлэлцүүлсэн хурлын тогтоол ба протокол:

